

БАТЛАВ:  
НИЙСЛЭЛИЙН ЗАМЫН ХӨГЖЛИЙН  
ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ  
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Г.БАЯРСАЙХАН

УЛААНБААТАР ХОТ, БАЯНГОЛ ДҮҮРЭГ, 2, 3, 4, 17, 18, 19 ДҮГЭЭР ХОРОО, АВТО  
ЗАМЫН ШИНЭЧЛЭЛТИЙН АЖЛЫН ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

1	Ерөнхий зүйл	<p>Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 2, 3, 4, 17, 18, 19 дүгээр хороонд хийгдэх авто зам, замын байгууламжийн шинэчлэлтийн ажлын бүрэлдэхүүн:</p> <ol style="list-style-type: none"><li>8 байршилд авто зам шинээр барих:<ul style="list-style-type: none"><li>44А байр орчмын авто зам</li><li>50 дугаар байрны зүүн талын далан руу гарах зам</li><li>66-р цэцэрлэгийн зүүн талын далан руу гарах зам</li><li>17/2 дугаар байр орчмын авто зам</li><li>Гаалийн байрны орчмын авто зам</li><li>17 дугаар байрны урд</li><li>Дамдинбазарын гудамжнаас далан хүртэлх авто зам</li><li>53 дугаар байрны урд талд</li></ul></li><li>7 байршилд авто замын засвар, шинэчлэлт хийх:<ul style="list-style-type: none"><li>Раднаабазарын гудамж</li><li>38 дугаар байрны зүүн талд</li><li>Цэрэнноровын гудамжийг Замчдын гудамжтай холбох</li><li>Гаалийн байрны дундах авто зам</li><li>13,14,15 дугаар байр орчмын авто зам</li><li>28/1,2,3-ын баруун талын зам</li><li>54 дугаар байрны баруун талд</li></ul></li><li>5 байршилд авто зогсоол шинээр барих:<ul style="list-style-type: none"><li>Тээврийн дээд сургуулийн хойд талд авто зогсоол</li><li>41 дугаар байрны зүүн талд</li><li>25 дугаар байрны урд талд</li><li>102 дугаар байр орчмын авто зам зогсоол</li><li>96 дугаар сургуулийн урд талд</li></ul></li></ol>
2	Барилгын талбайн үзүүлэлт	Нийт 8 байршилд авто зам шинээр барих, 7 байршилд авто замын засвар шинэчлэлт хийх, 5 байршилд авто зогсоол шинээр барих ажлууд хийгдэнэ.
3	Ажлын цар хүрээ	Эрх бүхий байгууллагаар батлагдсан авто зам, замын байгууламжийн зураг төслийн дагуу зам барилгын ажлыг гүйцэтгэнэ. Ажлын зураг төслөөс нарийвчлан үзнэ үү.
4	Ажлын хил хязгаар	Төсөлд Улаанбаатар хот, Баянгол дүүргийн 2, 3, 4, 17, 18, 19 дүгээр хороодын нутаг дэвсгэр хамаарна. (Ажлын зургаас нарийвчлан үзнэ үү.)

5	Барилгын ажлын зохион байгуулалт	<ol style="list-style-type: none"> <li>1. Гүйцэтгэгч гэрээ байгуулсны дараа ажил эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрөл олгох журмын дагуу зөвшөөрөл авна.</li> <li>2. Захиалагч барилгын ажлын талбайг гүйцэтгэгчид хүлээлгэн өгөх ба өгснөөс хойш ашиглалтад оруулах хүртэл хугацаанд гүйцэтгэгч нь ажлын талбайн аюулгүй байдлыг ханган ажиллана.</li> <li>3. Гүйцэтгэгч нь газар доорх болон дээрх инженерийн шугам сүлжээг чөлөөлөх, шилжүүлэх, хамгаалах, шинээр хийх ажлыг хариуцна. Үүнд: цахилгаан, холбоо, борооны ус зайлуулах, гэрэлтүүлэг гэх мэт.</li> <li>4. Гүйцэтгэгч нь төслийн газар чөлөөлөлт, нүүлгэн шилжүүлэлтийн ажил /байнгын болон түр ашиглах талбайг оролцуулан/-тай холбоотой дэвсгэр зургийг эрх бүхий байгууллагатай зөвшилцөж эцсийн байдлаар батлуулан захиалагчид хүлээлгэн өгнө.</li> <li>5. Барилга угсралтын ажлыг зохион байгуулахдаа тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг саадгүй нэвтрүүлэх арга хэмжээ авч, хөдөлмөр хамгаалал, аюулгүй байдал /түр зам, хаалт, тэмдэг, тэмдэглэгээ г.м./-ыг бүрэн хангаж ажиллана.</li> <li>6. Ажил гүйцэтгэх үедээ карьер нээх, хог хаягдал хаях, төвлөрсөн цэг нээх зэрэг ажлыг хэрэгжүүлэхтэй холбогдсон асуудлуудын талаар харьяалах дүүргийн засаг даргын албаны ажилтнууд болон байгаль орчны байцаагчтай харилцан зөвшилцөж ажиллана.</li> <li>7. Тухайн ажлыг хариуцан ажиллах инженер, техникийн ажилчид, нь уг ажлыг эхлэхээс ашиглалтад хүлээлгэн өгөх хүртэлх хугацаанд энэ төслөөс өөр төсөлд давхар ажиллахгүй болохыг анхаарч хүн хүч, машин механизмын хуваарилалтын графикийг батлуулж ажиллана. Үйлдвэрийн сертификат, итгэмжлэгдсэн лабораторийн дүгнэлтээр баталгаажсан чанарын шаардлага хангасан материалыг хэрэглэнэ.</li> <li>8. Гүйцэтгэгч компанийн товч танилцуулга, харилцах утас, гүйцэтгэж буй ажил, үйлчилгээний гэрээний үнийн дүн, ажил эхлэх дуусах хугацааг мэдээллийн самбарт үзүүлж олон нийтэд үзэгдэхүйц газар байрлуулна. Ажлыг батлагдсан төлөвлөгөө, графикийн дагуу гүйцэтгэнэ. Ажил гүйцэтгэх төлөвлөгөөнд шаардагдах хүн хүчний графикийг хамтатган батлуулна. Зам барилгын ажлыг гүйцэтгэхдээ явганаар зорчиж буй ард иргэдэд саад учруулахгүй байх. Тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг хаах нөхцөлд холбогдох байгууллагуудад урьдчилан мэдэгдэж, түр зам гаргаж байнгын арчилгаатай байлган оршин суугчдын ая тухтай зорчих нөхцөлийг ханган ажиллах, зохих зөвшөөрлийг авсан байх талаар анхаарч ажлын зохион байгуулалт, хөдөлмөр хамгаалалтын аюулгүй ажиллагааг нарийн баримтлан ажиллах шаардлагатай. НАЗХГ-ын даргын 2016 оны А/42 дугаар тушаалаар батлагдсан "Авто замын барилга, засварын хяналтын инженерийн гарын авлага"-ыг баримтлан гүйцэтгэнэ.</li> <li>9. Үйлдвэрийн сертификат, итгэмжлэгдсэн лабораторийн дүгнэлтээр баталгаажсан чанарын шаардлага хангасан материалыг хэрэглэнэ.</li> </ol>
---	----------------------------------	---

		<p>10. Гүйцэтгэгч 7 хоног тутамд хийгдсэн ажлын тайлбар болон тоо хэмжээг гарын авлагад заагдсан зааврын дагуу фото зургаар баримтжуулан холбогдох албан тушаалтнаар баталгаажуулж захиалагч талд албан бичгээр хүргүүлнэ. Зааврын дагуу фото зургаар баталгаажуулаагүй, 7 хоног тутмын тайланд тусгаагүй ажилбар бүрийг гүйцэтгэлээс хасаж тооцно. Зурган баримтжуулалтад зориулалтын метр, рейк, гадас, самбар ашиглана.</p> <p>11. Барилгын ажлын хүрээнд тусгай зөвшөөрөл бүхий үйлдвэрт бэлтгэсэн түүхий эд, материал хэрэглэх бөгөөд захиалагч байгууллагаас зөвшөөрөл авсны үндсэн дээр гэрээ байгуулна.</p>
6	Бусад	Авто замын барилгын ажил дууссан өдрөөс хойш 21 хоногийн дотор гүйцэтгэлийн баримт бичгийг захиалагчид цаасаар болон цахим хэлбэрээр хүлээлгэн өгнө.

**ХЯНАСАН:**

НЗХГ-ын Бодлого төлөвлөлтийн  
хэлтсийн дарга



В.Мягмар

**БОЛОВСРУУЛСАН:**

НЗХГ-ын Бодлого төлөвлөлтийн  
хэлтсийн мэргэжилтэн



Ц.Батжаргал

2024 оны 03 сарын 26 -ний өдөр